# Монгол Улс - Хүүхэд хөгжил судалгаа 2005

Үндэсний Статистикийн Хороо - ҮСХ

Үүссэн огноо: June 23, 2014

Вэб хуудас: <a href="http://web.nso.mn/nadamn/index.php">http://web.nso.mn/nadamn/index.php</a>

### Тойм

### Тодорхойлолт

#### **ДУГААР**

MNG-NSO-MN-MICS2005-v3.0

### Хувилбар

### ХУВИЛБАРЫН ТАЙЛБАР

х2.0: засварлагдсан мэдээлэл, зөвхөн дотоод хэрэгцээнд

#### ҮҮССЭН ОГНОО

2006-07-20

#### Тойм

#### ТОВЧ

НҮБ-ын Хүүхдийн Сангаас хэрэгжүүлдаг Олон Үзүүлэлтийн Бүлгийн Түүвэр Судалгаа (ОҮБТС) нь хүний хөгжлийг, тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүдийн байдлыг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулахад нь улс орнуудад дэмжлэг үзүүлдэг өрхөд суурилсөн хөтөлбөр юм. ОҮБТС-ны хүрээнд нийгмийн үзүүлэлтүүдийг статитсикийн үндэслэлтэйгээр олон улсад харьцуулахуйц түвшинд тооцох боломжтой. Энэ удаагийн ОҮБТС нь Мянганы Хөгжлийн Зорилт (МХЗ), Хүүхдэд Ээлтэй Дэлхий Ертөнц тунхаглал (ХЭДЕТ), түүнчлэн ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх НҮБ-ын Ерөнхий Ассемблейн онцгой чуулган гэх мэт бусад олон улсын шинжтэй зорилт, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэх, үнэлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах тал дээр онцгойлон анхаарсан.

НҮБ-ын тусгай чуулганаар "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалыг хэрэгжүүлэх үйл явцын талаар Монгол Улсын Засгийн газрын илтгэлийг 2007 онд хэлэлцэх болсонтой уялдуулан үндэсний илтгэлийг бэлтгэх ажлын хүрээнд Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, аж байдал, тэдний эрхийн хэрэгжилтийг гүнзгийрүүлэн судлах, түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010)" болон Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн явц, байдлыг хянах шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэх, үнэлгээ өгөх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран энэхүү судалгааг явууллаа.

#### Судалгааны зорилго

ОҮБТС - 3 судалгааны анхдагч зорилго нь дараах зүйлд оршино.

- Хүүхэд, эмэгтэйчүүдийн аж байдал, эрхийн хэрэгжилтийг үнэлэх шинэ мэдээлэл цуглуулах, байгаа мэдээллийг баяжуулах
- "Мянганы Тунхаглал" болон "Хүүхдэд Ээлтэй Дэлхий Ертөнц Тунхаглал" д дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хянах, цаашдын үйл ажиллагааг төлөвлөх суурь мэдээллийг бүрдүүлэх
- Энэ талаарх Монгол Улсын мэдээлэл, хяналтын системийг сайжруулахад хувь нэмэр оруулж, уг системийн загварыг бий болгох, хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох, дүн шинжилгээ хийх дадлага, туршлагыг нэмэгдүүлэх

#### Судалгааны төлөвлөлт

Үндэсний Статистикийн Газар нь уг Олон Үзүүлэлтийн Бүлгийн Түүвэр Судалгааг Монгол Улсын Засгийн Газар болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн тусламжтайгаар зохион байгуулсан. Судалгааны асуулга, түүвэрлэлт, зохион байгуулалт, мэдээлэл боловсруулалт, цуглуулалт, чанаржуулалт, дүн шинжилгээ хийх, тайлан бичих, тархаалт гэсэн асуудал тус бүр дээр НҮБ-ын Хүүхдийн Сангийн зүгээс бүсийн сургалтуудыг цувралаар зохион байгуулж техник, арга зүйгээр хангасан.

#### **МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ**

Түүвэр судалгааны мэдээлэл [тсм]

#### СУДАЛГААНЫ НЭГЖ

- Өрхүүд (нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийн бүлэг)
- Өрхийн гишүүд (урьд шөнө хамаарах өрхдөө хоноогүй ч гэсэн тухайн өрхөд голчлон амьдардаг хүмүүс, харин урьд шөнө хоносон зочин, гийчин нь өрхийн гишүүнд тооцогдохгүй)
- Өрхийн 15-49 насны эмэгтэйчүүд
- Өрхийн 0-4 насны хүүхдүүд

### Хүрээ

#### ТЭМДЭГЛЭЛҮҮД

Монгол Улсад явуулсан сүүлийн Олон Үзүүлэлтийн Бүлгийн Түүвэр Судалгаа нь асуулгынхаа хүрээнд дараах бүлэг асуудлуудыг хамарсан:

Өрхийн асуулга: Өрхийн шинж төрх, Боловсрол, Ундны ус, ариун цэврийн байгууламж, Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, Хүүхдийн хүмүүжил, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, Өрхийн орлого, Иоджуулсан давсны хэрэглээ

Өрхийн 15-49 насны эмэгтэйчүүдийн талаарх асуулга: Эмэгтэйн талаарх ерөнхий мэдээлэл, Хүүхдийн эндэгдэл, Эх болон нярайн эрүүл мэнд, Гэрлэлт, Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ, Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага, ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг

Өрхийн 5 хүртэлх насны хүүхдийн асуулга: Хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл, Төрсний бүртгэл, Сургуулийн өмнөх боловсрол олголт, Хүүхдийн хөгжил, "А" амин дэмийн хэрэглээ, Эхийн сүүгээр хооллолт, Өвчлөл, сувилгаа, Дархлаажуулалт, Хүүхдийн өсөлтийн үзүүлэлт

#### **TOPICS**

Агуулга	Үгийн сан	URI
Өрхийн шинж төрх	ОҮБТС-ны сэдэв	
Боловсрол	ОҮБТС-ны сэдэв	
Ундны ус, ариун цэврийн байгууламж	ОҮБТС-ны сэдэв	
Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	ОҮБТС-ны сэдэв	
Хүүхдийн хүмүүжил	ОҮБТС-ны сэдэв	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	ОҮБТС-ны сэдэв	
Өрхийн орлого	ОҮБТС-ны сэдэв	
Иоджуулсан давсны хэрэглээ	ОҮБТС-ны сэдэв	
Эмэгтэйн талаарх ерөнхий мэдээлэл	ОҮБТС-ны сэдэв	
Хүүхдийн эндэгдэл	ОҮБТС-ны сэдэв	
Эх болон нярайн эрүүл мэнд	ОҮБТС-ны сэдэв	
Гэрлэлт	ОҮБТС-ны сэдэв	
Жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгслийн хэрэглээ	ОҮБТС-ны сэдэв	
Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага	ОҮБТС-ны сэдэв	
ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг	ОҮБТС-ны сэдэв	
Хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл	ОҮБТС-ны сэдэв	
Төрсний бүртгэл болон сургуулийн өмнөх боловсрол олголт	ОҮБТС-ны сэдэв	
Хүүхдийн хөгжил	ОҮБТС-ны сэдэв	
"А" аминдэмийн хэрэглээ	ОҮБТС-ны сэдэв	

Агуулга	Үгийн сан	URI
Эхийн сүүгээр хооллолт	ОҮБТС-ны сэдэв	
Өвчлөл, сувилгаа	ОҮБТС-ны сэдэв	
Дархлаажуулалт	ОҮБТС-ны сэдэв	
Хүүхдийн өсөлтийн үзүүлэлт	ОҮБТС-ны сэдэв	

### Ажиглалтын хүрээ

#### ГАЗАР ЗҮЙН ХҮРЭЭ

Уг судалгааны үр дүн нь үндэсний түвшинд төдийгүй, хот, хөдөө, бүсийн (5 бүс - Баруун, Төв, Зүүн, Хангай, Улаанбаатар) түвшинд төлөөлөх чадвартай ба Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг хамарсан.

#### ХҮРЭЭ

Түүвэрлэгдсэн өрхийн бүх гишүүд (байнгын оршин суугчид), 15-49 насны байнгын оршин суугч бүх эмэгтэйчүүд, 0-4 насны (5 хүртэлх насны) байнгын оршин суугч бүх хүүхдүүд судалгаанд хамрагдсан.

### Гүйцэтгэгч болон түнш

#### **АНХНЫ ШИНЖЭЭЧ**

Нэр	Харьяалал
Үндэсний Статистикийн Хороо	

### БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ

Нэр	Харьяалал	Үүрэг
НҮБ-ын Хүүхдийн Сан, Монгол Улс	НҮБХС	Техникийн туслалцаа
НҮБ-ын Хүүхдийн сангийн бүсийн ОҮБТС-ын зохион байгуулагч	НҮБХС	Олон улсын техникийн туслалцаа
НҮБ-ын Хүүхдийн сангийн бүсийн Хяналт, үнэлгээний ажилтан	НҮБХС	Олон улсын техникийн туслалцаа
Стратеги Мэдээллийн Хэсэг, Бодлого Төлөвлөлтийн Хэлтэс, НҮБХС-ын Нью-Йорк дахь Төв байр	НҮБХС	Олон улсын техникийн туслалцаа

#### САНХҮҮЖИЛТ

Нэр	Товчлол	Үүрэг		
НҮБ-ын Хүүхдийн Сан НҮБХС		Судалгааг зохион байгуулахад санхүүгийн туслалцаа		
Монгол Улсын Сангийн Яам	СЯ	Судалгааг зохион байгуулахад санхүүгийн туслалцаа		

### Мета мэдээлэл боловсруулалт

#### БОЛОВСРУУЛСАН

Нэр	Товчлол	Харьяалал	Үүрэг
Намжилсүрэнгийн Уянга		ҮСГ	Баримтжуулалт хийсэн

#### МЕТА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛСАН ОГНОО

2008-02-08

#### **DDI БИЧИГ БАРИМТЫН ХУВИЛБАР**

Хувилбар 3.0

#### **DDI БИЧИГ БАРИМТЫН ДУГААР**

DDI-MNG-NSO-EN-MICS2005-v3.0

### Түүвэрлэлт

### Түүвэрлэлт

ОҮБТС - 3 судалгааны түүвэрлэлтийн зохиомжийн гол зорилго нь хүүхдийн амьдралын эрүүл хэв маягийг дэмжих, тэдэнд чанартай боловсрол олгох, харгис, ширүүн хандах явдал, мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах болон ХДХВ/ДОХ-той тэмцэх гэсэн Хүүхдэд Ээлтэй Дэлхий Ертөнц Тунхаглалд дэвшүүлсэн 4 гол зорилтын хэрэгжилтийг хянах бүлэг үзүүлэлтүүдийг бодитойгоор тооцох явдал юм. Судалгаанд түүвэрлэгдсэн өрхийн 15-49 насны бүх эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны бүх хүүхдүүд хамрагдсан. Монгол Улсын нийт өрхөөс тодорхой тооны өрхийг түүвэр болгон сонгон авч, уг өрхүүдийн байнгын оршин суугч 15-49 насны бүх эмэгтэйчүүдтэй тухайн эмэгтэйн талаар, байнгын оршин суугч 5 хүртэлх насны бүх хүүхдийн эх, асран хамгаалагчидтай нь тухайн хүүхдийн талаар тус тус ярилцлага хийсэн.

Уг судалгааны хүрээнд үндэсний болон бүсийн түвшинд төлөөлөх чадвартай өрх, эмэгтэй, хүүхдийн түүвэрлэлт хийсэн ба уг түүвэрлэлтийн дагуу мэдээлэл цуглуулсан. ОҮБТС - 3 судалгааны анхдагч зорилго нь Монгол Улсын хэмжээнд эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгаалал болон ХДХВ-ийн халдвартай холбоотой үзүүлэлтүүдийг тооцох, цаашлаад эдгээр үзүүлэлтүүдийг хот, хөдөөгөөр нь ялган тооцох явдал билээ. Монгол Улсын нутаг дэвсгэр нь засаг захиргааны хувьд бүсэд, бүс бүр нь аймгууд болон нийслэлд, аймаг бүр нь сумдад, нийслэл нь дүүргүүдэд, сум бүр нь багуудад, дүүрэг бүр нь хороодод тус тус хуваагддаг. Баг, хорооны өрх, хүн амын мэдээлэл жил бүр шинэчлэгдэж байгааг харгалзан баг, хороог түүврийн анхан шатны нэгжээр сонгосон бөгөөд түүврийн анхан шатны нэгж дэх өрхийн тоог ойролцоо байлгах зорилгоор олон өрхтэй баг, хороог 2-3 түүврийн нэгж болгон хуваасан. Түүврийн анхан шатны нэгж болох баг, хороог пропорциональ магадлалт түүврийн аргаар сонгож, сонгогдсон баг, хорооны өрхийн жагсаалтаас тус бүр 25 өрхийг системчилсэн цикл түүврийн аргаар сонгон авч судалсан болно. Түүврийн анхан шатны нэгжийг илэрхийлж буй хувьсагч нь түүвэрлэгдсэн нэгжийн дугаар буюу НН1 юм.

Уг судалгааны түүвэрлэлтийг хүүхэд, эмэгтэйчүүдийн байдлын талаарх үзүүлэлтийг үндэсний түвшинд, хот, хөдөө, бүс нутгаар тооцож гаргах зорилгоор хийсэн. Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар гэсэн 5 бүсийг түүврийн бүлэг болгон авч, өрхийн түүвэрлэлтийг хийхдээ бүсээс сонгогдох өрхийн тоог тухайн бүсийн хүн амын тоонд пропорционалиар хуваарилж, 2 шатат түүврийн аргыг ашиглав.

Судалгааны түүвэрт 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотыг төлөөлөх түүврийн 253 анхан шатны нэгжээс нийт 6325 өрхийг сонгож түүвэрт сонгогдсон өрхүүдээс мэдээллийг цуглуулж, судалгааны үр дүнгийн боловсруулалтыг үндэсний түвшинд хийхдээ түүврийн жинг ашигласан.

Хаягандаа олдохгүй болон ярилцлага авах боломжгүй өрх, хувь хүнийг өөр өрх, хувь хүнээр солих, орлуулан мэдээлэл авахыг ярилцлага авагч нарт зөвшөөрөөгүй. Харин өрх, хувь хүний хариулт өгөөгүй түвшинг засварлах үүднээс түүврийн жинд зохих засваруудыг ОҮБТС-ны нэгдсэн зааврын дагуу хийсэн.

### Түүврийн хэлбэлзэл

Үндсэн түүвэрлэлтийн зохиомжид ямар нэг томоохон өөрчлөлт ороогүй ба түүврийн анхан шатны бүх нэгжээс хангалттай өндөр хамрагдалтын түвшинтэйгээр мэдээлэл цуглуулсан.

### Хамралтын тувшин

Судалгааны түүвэрт сонгогдсон 6325 өрхөөс 6220 нь ярилцлагад хамрагдаж, хамрагдалтын түвшин 98.3 хувь байсан. Судалгаанд хамрагдсан өрхүүдэд эмэгтэйчүүдийн асуулгад хамрагдвал зохих 15-49 насны 8057 эмэгтэй бүртгэгдсэнээс 7459 эмэгтэй ганцаарчилсан ярилцлагад хамрагдаж, хамрагдалтын түвшин 92.6 хувь байлаа. Дээрх өрхүүдэд хүүхдийн асуулгад хамрагдвал зохих 5 хүртэлх насны 3568 хүүхэд бүртгэгдсэний 99.4 хувь буюу 3547 хүүхэд судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн ерөнхий хамрагдалтын түвшин нь 91.0 хувь, 5 хүртэлх насны хүүхдийн хувьд ерөнхий хамрагдалтын түвшин нь 97.8 хувь байсан.

### Түүврийн жин

Судалгааны мэдээллийн файл бүрт түүврийн жин тооцсон.

Өрхийн мэдээллийн файлын хувьд түүврийн жинг өрхийн сонгогдох магадлалын эсрэг магадлалаар түүврийн бүлэг (бүс бүрийн хувьд хот, хөдөө) бүрийн хувьд тооцсон. Өрхийн асуулгад хариулт өгөөгүй түвшинг засварлах үүднээс өрхийн түүврийн жинг түүврийн бүлэг бүрийн хувьд засварласан ба нийт жинлэгдсэн өрхийн тоог жинлэгдээгүй өрхийн тоотой тэнцүү байлгах үүднээс түүврийн жинг тогтмол тоогоор үржүүлж нормчилсон. Өрхийн түүврийн жингийн хувьсагчийг HHWEIGHT гэж нэрлэсэн ба үүнийг өрхийн мэдээллийн файл - HH, өрийн гишүүдийн мэдээллийн файл - HL тус бүрт ашигласан.

Эмэгтэйчүүдийн мэдээллийн файлын хувьд нормчлоогүй өрхийн түүврийн жинг ашигласан. Эмэгтэйн ганцаарчилсан асуулгад хариулт өгөөгүй түвшинг засварлах үүднээс эмэгтэйн түүврийн жинг түүврийн бүлэг бүрийн хувьд засварласан ба нийт жинлэгдсэн эмэгтэйн тоог жинлэгдээгүй эмэгтэйн тоотой тэнцүү байлгах үүднээс түүврийн жинг тогтмол тоогоор үржүүлж нормчилсон.

Хүүхдийн мэдээллийн файлын хувьд мөн нормчлоогүй өрхийн түүврийн жинг ашигласан. Хүүхдийн асуулгад хариулт өгөөгүй түвшинг засварлах үүднээс хүүхдийн түүврийн жинг түүврийн бүлэг бүрийн хувьд засварласан ба нийт жинлэгдсэн хүүхдийн тоог жинлэгдээгүй хүүхдийн тоотой тэнцүү байлгах үүднээс түүврийн жинг тогтмол тоогоор үржүүлж нормчилсон.

### Асуулгууд

### Тойм

Судалгааны асуулгыг боловсруулахдаа судалгааны зорилго, хамрах хүрээг харгалзан НҮБ-ын Хүүхдийн Сангийн санал болгосон загвар асуулгуудыг ашигласан. Өрхийн сууцны хангамж, ахуй нөхцөл, өрхийн гишүүдийн талаарх өрхийн асуулгыг судалгаанд хамрагдахаар сонгогдсон өрхийн тэргүүлэгч эсвэл өрхийн гишүүд болон өрхийн талаар дэлгэрэнгүй хариулт өгч чадахуйц өрхийн гишүүнтэй ярилцах замаар бөглөсөн. Өрхийн асуулга нь өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл, боловсрол, ундны ус, ариун цэврийн байгууламж, өрхийн шинж төрх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хүмүүжил, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өрхийн орлого, иоджуулсан давсны хэрэглээ гэсэн бүлэг асуудлуудыг хамарсан асуултуудтай.

Судалгаанд өөрийн орны онцлогийг тусгасан зарим бүлэг, асуултыг, тухайлбал өрхийн асуулгын "Иоджуулсан давсны хэрэглээ" гэсэн бүлэгт эрдэс амин дэмээр баяжуулсан гурилын хэрэглээний талаарх асуулт, "Хүүхдийн хүмүүжил" бүлэгт хүүхдийн төлөвшил, хэв зуршлын асуудлаарх дэд бүлгийг судалгааны ажлын хэсэг, Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу нэмж оруулав.

Судалгаанд хамрагдсан өрхийн хүнсэндээ хэрэглэж байгаа давсны иоджилтыг хурдавчилсан шалгуур ашиглан тогтоосон.

Дээрх хэлсэнчлэн өрхийн асуулгыг өрхийн талаар сайн мэдэх, өрхийн насанд хүрсэн аль нэг гишүүнээс, эмэгтэйчүүдийн асуулгыг өөрөөс нь, 5 хүртэлх насны хүүхдийн асуулгыг хүүхдийн эх/асран хамгаалагчаас асууж, хүүхдийн жин, өндрийн хэмжилтийг хийсэн болно.

Эмэгтэйчүүдийн асуулга нь эмэгтэйн талаарх ерөнхий мэдээлэл, хүүхдийн эндэгдэл, эх болон нярайн эрүүл мэнд, гэрлэлт, жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгслийн хэрэглээ, гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага, ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг гэсэн бүлэг асуудлуудыг хамарсан асуултуудтай.

5 хүртэлх насны хүүхдийн асуулга нь хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл, төрсний бүртгэл болон сургуулийн өмнөх боловсрол олголт, хүүхдийн хөгжил, "А" аминдэмийн хэрэглээ, эхийн сүүгээр хооллолт, өвчлөл, сувилгаа, дархлаажуулалт, хүүхдийн өсөлтийн үзүүлэлт гэсэн бүлэг асуудлуудыг хамарсан асуултуудтай.

Судалгааны асуулгуудыг НҮБ-ын санал болгосон загвар асуулгууд дээр суурилан эхлээд Монгол хэл дээр боловсруулсан ба дараа нь Англи хэл рүү орчуулсан.

Асуулгын хуудасны асуултууд хүмүүст хэр ойлгогдож байгаа, асуулт хоорондын уялдаа холбоо, нэг өрхөөс судалгаа авахад зарцуулах хугацааг тодорхойлох, программыг турших зорилгоор туршилтын судалгааг Төв аймгийн Эрдэнэ суманд 2005 оны 9 сард зохион байгуулж явуулсан. Энэ туршилтын судалгааны үр дүнд тулгуурлан асуулгын томъёолол, найруулга, асуултуудын хоорондын уялдаа холбоог сайжруулан боловсруулав.

### Мэдээлэл цуглуулалт

### Мэдээлэл цуглуулалтын огноо

**Эхлэх Дуусах Цикл** 2005-11 2005-12 N/A

### Мэдээлэл цуглуулалтын бодлого

ганцаарчилсан ярилцлага [гя]

#### МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Судалгааны ажилтнуудад зориулсан сургалтыг ҮСГ-т 2005 оны 10, 11-р саруудад 10 хоногийн хугацаатай зохион байгуулж, судалгааны асуулгад орсон бүлэг тус бүр дээр холбогдох мэргэжлийн хүмүүсээр хичээл заалгаж, дадлага хийлгэн сургалтад оролцогчдоос шалгалт авч судалгаанд ажиллах ажилтнуудыг сонгон шалгаруулж авсан болно.

Судалгаанд баг бүрийг нэг ахлагч, нэг хянагч ба засварлагч, 5 ярилцлага авагч бүгд 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэх нийт 11 багийг зохион байгуулж ажиллуулав.

Мэдээллийг 2005 оны 11, 12 дугаар сард цуглуулсан. Энэ ажлын явц, чанарт ҮСГ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн ажилтан нар, судалгааны Удирдлагын Зөвлөлийн гишүүд хяналт тавин ажиллаж, гарсан ололт, дутагдлыг тухай бүр танилцуулж, шаардагдах арга хэмжээг авч ажилласан.

### Мэдээлэл цуглуулалт

Нэр	Товчлол	Харьяалал
Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар	ҮСГ	

#### **SUPERVISION**

Судалгааны баг бүр нь нэг ахлагч, нэг хянагч ба засварлагч, 3-4 эмэгтэй ярилцлага авагч, 1-2 эрэгтэй ярилцлага авагч, 1 жолооч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажилласан ба түүврийн нэгж хооронд, өрх хооронд явахдаа машинаар явсан.

Багийн ахлагчийн үүрэг нь мэдээлэл цуглуулахтай холбогдон гарах бүхий л үйл ажиллагааг зохион байгуулах явдал байсан. Тухайлбал, багийн гишүүдийн ажлын хуваарилалт, машин, тоног төхөөрөмж, хэрэгцээтэй зүйлс, цалин, мөнгө, газрын зураг, өрхийн жагсаалт зэргийн хангалт, судалгааны төлөвлөлт, орон нутгийн удирдлага, холбогдох хүмүүстэй уулзалт, байр, хоол хүнсний зохицуулалт гэх мэт. Мөн багийн ахлагч нь ярилцлага авагч нарын ажлыг хянах, мэдээлэл цуглуулалтын ажилтай холбоотой илтгэл бичих, бөглөгдсөн асуулгуудыг ҮСГ-т илгээх, илтгэх зэрэг үүрэгтэй ажилласан.

Багийн хянагч ба засварлагч нь өдөр бүрийн эцэст бөглөгдсөн асуулга бүрийг шалгах, тодруулбал, асуугдаагүй орхигдсон асуулт байгаа эсэх, үсрэлтийг зөв хийсэн эсэх, буруу бөглөгдсөн асуулт байгаа эсэх, нийцэмжгүй хариулт байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгах үүрэгтэй байсан. Мөн ярилцлагыг хөндлөнгөөс ажиглах, ярилцлага авагч нартай тэдний гаргасан алдаа, дутагдлын талаар уулзах, ярилцах үүрэгтэй ажилласан.

Багийн ахлагч, хянагч ба засварлагчийн үүргийн талаар дэлгэрэнгүйг Ахлагч, хянагч ба засварлагчийн заавраас харж болно. ҮСГ-ын судалгааг зохион байгуулсан мэргэжилтэн нар судалгааны баг бүрт хүрч очин, хяналт тавьж, гарсан алдаа дутагдлыг газар дээр нь арилгах, сануулах тал дээр арга хэмжээ авч ажилласан.

### Мэдээлэл боловсруулалт

### Мэдээлэл засалт

Мэдээлэл засварлалтын ажлын дараах үе шатуудтай хэрэгжүүлсэн:

- а) Ажлын байран дээрх шалгалт, кодлолт
- b) Мэдээлэл шивэлтийн үеийн засварлалт
- с) Шивэгдсэн мэдээллийн бүтэц болон бүрэн байдлын шалгалт
- d) Хоёр дахь шатны засварлалт
- e) SPSS формат бүхий файлын бүтцийн шалгалт

Мэдээлэл засварлалттай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг Мэдээлэл боловсруулалтын гарын авлагаас харж болох ба уг гарын авлагыг дараах вэб хуудсаас татаж авах боломжтой байгаа. http://www.childinfo.org/mics/mics3/manual.php

### Бусад боловсруулалт

Мэдээллийг түүврийн нэгж бүрээр тус тусад нь шивсэн ба нэгж бүрийн мэдээллийг дараах үе шаттайгаар боловсруулсан:

- 1) Бөглөгдсөн асуулга хүлээн авалт
- 2) Ажлын байран дээрх засварлалт, кодлолт
- 3) Мэдээлэл шивэлт
- 4) Шивэгдсэн мэдээллийн бүтэц болон бүрэн байдлын шалгалт
- 5) Дахин шивэлт
- 6) Дахин шивэгдсэн мэдээллийн өмнө шивэгдсэн мэдээлэлтэй харьцуулалт
- 7) Анхдагч шивэгдсэн мэдээллийн нөөцлөлт
- 8) Хоёр дахь шатны засварлалт
- 9) Засварлагдсан мэдээллийн нөөцлөлт

Бүх түүврийн нэгжийн мэдээллийг дээрх үе шатын дагуу боловсруулсны дараа, бүх мэдээллийг нэгтгээд мэдээллийн файл бүрийг дараах үе шаттайгаар боловсруулсан:

10) Шивэгдсэн мэдээллийн 4 тусдаа SPSS формат бүхий файл болгон экспортлолт

(үүнд: hh - өрхийн мэдээллийн файл, hl - өрхийн гишүүдийн мэдээллийн файл, wm - 15-49 насны эмэгтэйн мэдээллийн файл, ch - 5 хүртэлх насны хүүхдийн мэдээллийн файл)

- 11) Шинжилгээ хийх зорилгоор шаардлагатай хувьсагчдын утгын дахин кодлолт
- 12) Түүврийн жин нэмэлт
- 13) Аж байдлын индекс тооцолт, тооцсон индексийн мэдээлэлд нэгтгэлт
- 14) SPSS формат бүхий файлын бүтцийн шалгалт
- 15) Мэдээллийн чанарын хүснэгт боловсруулалт
- 16) Үр дүнгийн хүснэгт боловсруулалт

Дээрх үе шатуудтай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг Мэдээлэл боловсруулалтын гарын авлага, Мэдээлэл засварлалтын гарын авлага, Мэдээлэл боловсруулалтын програмууд (SPSS, CSPro), Үр дүнгийн хүснэгт боловсруулалтын гарын авлага зэргээс харж болох ба уг гарын авлагуудыг дараах вэб хуудсаас татаж авах боломжтой байгаа.

http://www.childinfo.org/mics/mics3/manual.php

Мэдээлэл шивэлтийн ажлыг мэдээлэл боловсруулалтын ахлагчийн удирдлаган дор 8 мэдээлэл шивэлтийн оператор нийт 9 компьютер (мэдээлэл шивэлтийн операторын 8 компьютер, мэдээлэл боловсруулалтын ахлагчийн 1 компьютер) дээр хийж гүйцэтгэсэн. Бүх мэдээллийг мэдээлэл шивэлтийн зааврын дагуу ҮСГ дээр төвлөрүүлэн шивсэн. Мэдээлэл шивэлтийн програмыг CSPro програмын 2.6.007 хувилбарыг ашиглан, шивэгдэн орж буй хувьсагч бүрийн утгыг хянадаг байхаар боловсруулсан. Үсрэлтийн болон хязгаарын утгаас хэтрэлтийн алдаа бүрийг уг програмаар хянаж байсан ба мэдээлэл шивэлтийн оператор хүчээр мэдээлэл оруулах боломжгүй байсан. Мөн зарим нийцэмжгүй хариултыг шалгах шалгалтыг мэдээлэл шивэлтийг програмд програмчилж өгсөн. Цаашлаад, мэдээлэл шивэлтийн програм нь хүүхдийн өсөлтийн үзүүлэлт болох Z үзүүлэлтийг автоматаар тооцдог байхаар боловсруулагдсан. Нээлттэй хариулт өгч болох асуултуудад "Бусад" гэж хариулаад хариулт бичих хэсэгт ямар нэг хариултыг үгээр бичсэн тохиолдолд уг хариулт нь өмнө байгаа хариултуудын аль нэгд хамаарагдахааргүй байвал түүнийг програмаар шивээгүй.

Түүврийн нэгж бүрийн хувьд бүх асуулгын хуудсын мэдээлэл бүрэн шивэгдсэн, судалгаанд хамрагдвал зохих бүх эмэгтэй болон хүүхдийн асуулга бүрэн байсан, мэдээлэл нь бүрэн шивэгдсэн эсэхийг бүтэц болон бүрэн байдлын шалгалтаар илрүүлж байсан.

Дахин шивэлтийг бүх түүврийн нэгжийн хувьд гүйцэтгэсэн. Үүний дараа дахин шивэлтээр үүссэн файлыг анхны шивэлтээр үүссэн файлтай харьцуулж, алдаа илэрвэл түүнийг анхны шивэлтийн файл дээр засах замаар зөв болгож байсан.

Мэдээлэл шивэлтийн програмаар бүх мэдээллийг шивж дуусаад, түүврийн нэгж бүрийн шивэгдсэн файлыг нөөцөлж авсан. Үүний дараа тэдгээрийг нэгтгэх ажиллагаа хийгдсэн.

Үр дүнгийн хүснэгт боловсруулалтын ажлыг SPSS програмын 13.0 болон 14.0 хувилбаруудыг ашигласан. 13.0 хувилбар нь үндсэндээ хүүхдийн эндэгдлийн хүснэгтээс бусад бүх үр дүнгийн хүснэгтийг боловсруулахад ашиглагдсан. Хүүхдийн эндэгдлийн хүснэгт, мэдээллийн чанарын хүснэгт болон бусад шинжилгээний боловсруулалтанд 14.0 хувилбарыг ашигласан.

Шивэгдсэн бүх мэдээллийг SPSS формат бүхий файл болгон хөрвүүлсний дараа үр дүнгийн хүснэгтэнд ашиглах зорилгоор зарим нэг хувьсагчийн утгыг дахин кодлосон. Тухайлбал, нас, боловсрол, газарзүйн байршил гэх мэт. Нас болон огноог дахин кодпохдоо "Мэдэхгүй" гэсэн хариулт болон хариулаагүй орхигдсон асуултуудыг багасгах зорилгоор зарим нэг санамсаргүй кодлолт, тооцоололт хийсэн.

Судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхэд ашигласан өөр нэг чухал хүчин зүйл бол өрхийн аж байдал юм. Өмнө нь уламжлалт аргаар өрхийн орлого, зарлагын мэдээллийг үндэслэн өрхийн эдийн засгийн байдлыг тодорхойлж байсан. Энэ аргаар мэдээлэл цуглуулахад цаг хугацаа их шаардах (өрхийн гишүүн бүрийн орлогыг эх үүсвэр тус бүрээр асуухад олон асуулт асуух шаардлагатай болдог) бөгөөд мэдээллийг дутуу цуглуулах (ярилцлага өгч байгаа хүн өрхийн бусад гишүүдийн орлого, зарлагын талаар тодорхой мэдэхгүй байх), өрхийн үйлдвэрлэл, тогтмол бус болон өндөр орлогыг тооцож оруулахад хүндрэл бэрхшээлтэй байдаг гэх зэрэг бэрхшээл тулгардаг. Иймээс энэ судалгаанд өрхийн аж байдлыг хэмжих "Аж байдлын индекс" үзүүлэлтийг тооцож ашигласан. Аж байдлын индексийг тооцоход цөөн тооны, төвөгтэй бус асуулт шаардлагатай бөгөөд өөр зорилгоор асуусан асуулт (ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, сууцны төрөл, сууцны материал, цахилгаан гэрэлтэй эсэх г.м)-ыг авч ашиглах боломжтой юм. Энэхүү судалгааны үр дүнг өрхийн аж байдлын индексийн 5 тэнцүү бүлгээр гаргасан бөгөөд сууцны төрөл, нөхцөл, ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдсан байдал, цахилгаан гэрэлтэй эсэх, өрхийн хэрэглээний эд зүйл (харилцаа холбооны болон тээврийн хэрэгсэл, гэр ахуйн цахилгаан бараа гэх мэт) байгаа эсэх гэсэн үзүүлэлтийг сонгон авч судалсан. Дээрх үзүүлэлтүүдийг ашиглан өрхүүдэд оноо ногдуулж оноогоор нь ядуугаас чинээлэг гэсэн зэргээр эрэмбэлсэн. Ингээд онооны эрэмбээр нийт өрхийг 5 тэнцүү бүлэгт хувааж ядуу (I), ядуувтар (III), дунд зэрэг (IIII), дундаас дээш (IV), чинээлэг (V) гэж ангилан гаргасан.

Судалгааны үр дүнг улсын дундаж болон бүс нутаг, өрхийн байршил, хот хөдөөгөөр эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, өрхийн аж байдлын индексийн 5 тэнцүү бүлгээр тооцсон.

Бүс нутаг: Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар

Байршил: Нийслэл хот, аймгийн төв, сумын төв, хөдөө

Хот, хөдөө: Нийслэл хот, аймгийн төвийг "хот", сумын төв, хөдөөг "хөдөө" хэмээн тооцсон.

Боловсролын түвшин: Эхийн боловсролыг боловсролгүй (бага боловсрол эзэмшээгүй), бага, бүрэн бус дунд, бүрэн дунд, мэргэжлийн анхан шатны, дипломын дээд ба түүнээс дээш боловсролтой гэсэн 6 түвшингээр авч үзсэн.

Аж байдлын индекс: Ядуу (I), Ядуувтар (II), Дунд зэрэг (III), Дундаас дээш (IV), Чинээлэг (V)

### Мэдээллийн үнэлэлт

### Түүвэрлэлтийн алдааны үнэлэлт

Түүвэр судалгааны үр дүн, тооцоололтонд 2 төрлийн алдаа нөлөөлдөг: 1) түүвэрлэлтийн бус алдаа 2) түүвэрлэлтийн алдаа. Түүвэрлэлтийн бус алдаа гэдэг нь мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын ажлын явцад гарсан алдааны үр дүн юм. ОҮБТС - 3 судалгааны үед энэ төрлийн алдааг багасгах арга хэмжээг тухай бүр авч ажилласан хэдий ч энэ төрлийн алдааг статистик аргаар үнэлэх, огт гаргахгүй байх боломжгүй юм.

Харин түүвэрлэлтийн алдааг статистик аргаар үнэлэх боломжтой байдаг. ОҮБТС - 3 судалгааны мэдээлэгчдийг сонгож авсан түүвэр нь ерөнхий олонлогоос түүврийн арга, түүврийн хэмжээг ашиглан түүвэрлэлт хийж болох түүврийн олон аргуудын нэг нь юм. Түүврийн өөр олон аргуудын аль нь ч энэхүү сонгон авч ашигласан түүврийн аргын үр дүнгээс бага зэрэг ялгаатай үр дүнг гаргаж болно. Түүвэрлэлтийн алдаа нь бүх боломжит түүврийн хоорондын хэлбэлзлийг хэмждэг. Энэхүү хэлбэлзлийн хэмжээг нарийвчлан тодорхойлоход бэрхшээлтэй боловч судалгааны үр дүнг үндэслэн статистикийн аргаар үнэлж болдог. Ихэвчлэн стандарт алдааг ашиглан түүвэрлэлтийн алдааг тодорхой үзүүлэлт (дундаж, харьцаа г.м)-ийн хувьд хэмжинэ. Стандарт алдаа нь вариацаас квадрат язгуур авсантай тэнцэнэ. Итгэмжлэгдэх хязгаарыг ерөнхий олонлогийн бодит тоо нилээд буурсан байх интервалыг харуулахын тулд тооцдог. Судалгаанаас тооцсон ямар ч статистик үзүүлэлтийн хувьд тухайн статистик үзүүлэлтийн утга нь түүний стандарт алдааг 2 дахин үржүүлснийг нэмж, хассан хязгаарын (р + 2.se, р - 2.se) дотор буурна гэдэг нь адил түүврийн хэмжээ, аргыг ашигласан бүх боломжит түүвэрлэлтийн 95 хувьд тохиолдохыг харуулна.

Хэрэв судалгааны түүвэрлэлтэнд энгийн санамсаргүй түүвэрлэлтийн арга ашигласан бол түүвэрлэлтийн алдааг үнэлэхдээ шулуун шугамын аргаар үнэлэх боломжтой байдаг. Харин ОҮБТС - 3 судалгааны түүвэрлэлтэнд 2 шатат түүвэрлэлтийн аргыг ашигласан тул илүү цогц томъёолол ашиглах шаардлагатай байсан. Тиймээс тус судалгааны хувьд түүвэрлэлтийн алдааг үнэлэхдээ SPSS програмаар боловсруулсан түүврийн цогц модуль буюу програмчлалыг ашигласан. Тодруулбал, стандарт алдааг үнэлэхдээ Тейлорын шугаман аргын дагуу үнэлсэн ба түүнийг SPSS програмд програмчилж оруулан түүгээрээр үнэлгээ хийсэн гэсэн үг юм. Тейлорын шугаман аргын талаар SPSS програмын Help цэсээс харах боломжтой.

Түүвэрлэлтийн алдааг гол үзүүлэлтүүдийн хувьд улсын түвшинд, бүсүүдээр, хот, хөдөө гэсэн ангилалаар тооцсон. Үзүүлэлт бүрийн хувьд тухайн үзүүлэлтийн тооцсон утга, стандарт алдаа, вариацийн коэффициент (стандарт алдааг тухайн үзүүлэлтийн утгад харьцуулсан харьцаа), хэрэглэсэн түүвэрлэлтийн аргын нөлөө, уг нөлөөний квадрат язгуур (тухайн судалгаанд хэрэглэсэн түүвэрлэлтийн аргын үзүүлэлтийн хэлбэлзлийг энгийн санамсаргүй түүвэрлэлтийн арга дахь хэлбэлзэлтэй харьцуулсан харьцаа), итгэмжлэгдэх хязгаар зэргийг тооцсон.

Түүвэрлэлтийн алдааны үнэлгээний талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны Үндсэн тайлангийн Түүвэрлэлтийн алдаа гэсэн гарчгаас үзнэ үү.

### Мэдээлэл үнэлэлтийн бусад хэлбэр

Судалгааны мэдээллийн чанарыг дараах хүснэгтүүдээс харах боломжтой:

Өрхийн хүн амын насжилтийн тархалт

Судалгаанд хамрагдвал зохих болон хамрагдсан эмэгтэйчүүдийн насжилтын тархалт

Судалгаанд хамрагдвал зохих болон хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдүүдийн насжилтын тархалт

5 хүртэлх насны хүүхдүүдийн насжилтын тархалт, 3 сарын насны бүлгээр

Хамрагдвал зохих насны хязгаар дахь нас ба хугацааны харьцаа

Бүрэн бус мэдээллийн хувь, зарим үзүүлэлтээр

5 хүртэлх насны хүүхдийн талаар асуулгад хариулсан эх, асран хамгаалагч нь хамт амьдардаг эсэх Сургуульд хамрагдалт, насаар

Төрүүлсэн болон амьд байгаа хүүхдүүдийн төрөх үеийн хүйсийн харьцаа

Эмэгтэйчүүдийн тоо, сүүлчийн төрөлтөөс хойшхи хугацаагаар

Дээрх мэдээллийн чанарын хүснэгтүүдийн тоог судалгааны Үндсэн тайлангийн зохих хавсралтаас үзнэ үү.

# Файлын тайлбар

## variable\_list

### Household

Хувьсагч

Агуулга Өрхийн мэдээллийн файл (ОҮБТС өрхийн асуулга: өрхийн шинж төрх, ундны ус, ариун цэврийн

байгууламж, хүүхдийн хүмүүжил, өрхийн орлого, иоджуулсан давсны хэрэглээ гэсэн бүлгүүд)

Тохиолдолууд 6325

Бүтэц Төрөл: relational

158

Түлхүүрүүд: НН1(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), НН2(Өрхийн дугаар)

Хувилбар х2.0: засварлагдсан мэдээлэл, зөвхөн дотоод хэрэгцээнд

Гүйцэтгэгч Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар

Мэдээллийн файлд байгаа онцлог хариулт болон орхигдсон хариултуудыг дараах маягаар кодлосон: Асуулгын дагуу зарим асуултыг асуулгүй үсрэх тохиолдол байдаг ба энэ тохиолдолд хариултыг хоосон орхисон байгаа. Зарим асуугдах ёстой асуултын хувьд мэдээлэгч ямар нэг хариулт өгөөгүй байвал түүнийг компьютерт шивэхдээ тоон төрлийн хариулт авах асуултын хувьд 9, 99, ..., тэмдэгт төрлийн хариулт авах асуултын хувьд ?, ??, ... гэх мэтээр кодлож шивсэн.

Бусад онцгой хариултыг дараах байдлаар кодлосон. Үүнд: тоон төрлийн хариулт авах асуултын хувьд Мэдэхгүй 8, 98, ... Таарахгүй 7, 97, ... Бусад 6, 96, ... Харин, тэмдэгт төрлийн хариулт авах асуултын хувьд: Мэдэхгүй 7 Аль нь ч биш Ү Бусад X Нэгтгэн дугнэвэл: 1 орон 2 орон 3 орон 4

асуултын хувьд: Мэдэхгүй Z Аль нь ч биш Y Бусад X Нэгтгэн дүгнэвэл: 1 орон 2 орон 3 орон 4 орон Тэмдэгт Хариулах ёсгүй . . . . Орхигдсон 9 99 999 9999 ? Мэдэхгүй 8 98 998 8 9998 Z Таарахгүй 7 97 997 9997 Аль нь ч биш 0 00 000 0000 Y Бусад 6 96 996 9996 X Онцлог хариулт

95,94,... 995,994,... 9995,9994,... W

### Хувьсагчид

Missing Data

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1	нн1	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	discrete	numeric	
V2	HH2	Өрхийн дугаар	discrete	numeric	
V3	HH6w	Байршил	discrete	numeric	
V4	HH7w	Аймаг, нийслэл	discrete	numeric	
V5	НН9	Ярилцлагын дүн	discrete	numeric	
V6	НН9А	Өрхөд очсон тоо	discrete	numeric	
V7	HH11	Ам бүлийн тоо	contin	numeric	
V8	HH12	Өрхийн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V9	HH13	Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V10	HH14	Өрхийн 5 хүртэлх насны хүүхдийн тоо	contin	numeric	
V11	HH15	Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдийн тоо	contin	numeric	
V12	TOHL6	Өрхийн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V13	TOHL7	Өрхийн 5-17 насны хүүхдийн тоо	contin	numeric	
V14	TOHL8	Өрхийн 5 хүртэлх насны хүүхдийн тоо	contin	numeric	
V15	TOHL9	Нас барсан эхийн тоо	contin	numeric	
V16	TOHL11	Нас барсан эцгийн тоо	contin	numeric	
V17	WS1	Ундны усны гол эх үүсвэр	discrete	numeric	Танайх ундны усаа голдуу ямар эх үүсвэрээс авдаг вэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V18	WS3	Ундны усаа авахдаа зарцуулдаг хугацаа	discrete	numeric	Ундны усаа авахдаа хэдэн цаг зарцуулдаг вэ?
V19	WS4	Ундны усандаа явдаг хүн	discrete	numeric	Ундны усандаа хэн голдуу явдаг вэ? Тандах асуулт: Ундны усандаа голдуу явдаг хүн 15-аас дээш настай юу? Эрэгтэй юу, эмэгтэй юу?
V20	WS5	Ундны усаа найдвартай байлгахын тулд арга хэрэглэдэг	discrete	numeric	Ундны усаа найдвартай байлгахын тулд ямар нэгэн арга хэрэглэдэг үү?
V21	WS6A	Буцалгадаг	discrete	character	Ундны усаа найдвартай байлгахын тулд голдуу ямар арга хэрэглэдэг вэ? Өөр?
V22	WS6B	Ариутгалын бодис хэрэглэдэг	discrete	character	Ундны усаа найдвартай байлгахын тулд голдуу ямар арга хэрэглэдэг вэ? Өөр?
V23	WS6C	Даавуу /марль/-аар шүүдэг	discrete	character	Ундны усаа найдвартай байлгахын тулд голдуу ямар арга хэрэглэдэг вэ? Өөр?
V24	WS6D	Ус цэвэршүүлэгч хэрэглэдэг	discrete	character	Ундны усаа найдвартай байлгахын тулд голдуу ямар арга хэрэглэдэг вэ? Өөр?
V25	WS6X	Бусад	discrete	character	Ундны усаа найдвартай байлгахын тулд голдуу ямар арга хэрэглэдэг вэ? Өөр?
V26	WS6Z	Мэдэхгүй	discrete	character	Ундны усаа найдвартай байлгахын тулд голдуу ямар арга хэрэглэдэг вэ? Өөр?
V27	WS7	Жорлонгийн төрөл	discrete	numeric	Танайх ямар жорлон хэрэглэдэг вэ? "Ус татдаг" гэсэн тохиолдолд тандах асуулт: Татсан ус хаашаа урсдаг/ордог вэ?
V28	WS8	Жорлонгоо бусад өрхүүдтэй хамтарч хэрэглэдэг	discrete	numeric	Жорлонгоо бусад өрхүүдтэй хамтарч хэрэглэдэг үү?
V29	WS9	Жорлонгоо хамтарч хэрэглэдэг өрхийн тоо	contin	numeric	Хэдэн өрх хамтарч хэрэглэдэг вэ?
V30	HC1A	Өрхийн тэргүүлэгчийн шүтдэг шашин	discrete	numeric	Өрхийн тэргүүлэгчийн шүтдэг шашинг хэлнэ үү?
V31	HC1B	Өрхийн тэргүүлэгчийн эх хэл	discrete	numeric	Өрхийн тэргүүлэгчийн эх хэлийг хэлнэ үү?
V32	HC1C	Өрхийн тэргүүлэгчийн яс, үндэс	discrete	numeric	Өрхийн тэргүүлэгчийн яс, үндсийг хэлнэ үү?
V33	HC1D	Сууцны төрөл	discrete	numeric	Танай өрх ямар төрлийн сууцанд амьдардаг вэ?
V34	HC1F	Сууцны талбай	contin	numeric	Танай өрхийн амьдардаг сууцны талбай хэд вэ?
V35	HC1G	Өрөөний тоо	contin	numeric	Танай өрх хэдэн өрөөтэй сууцанд амьдардаг вэ?
V36	HC2	Унтлагын өрөөний тоо	contin	numeric	Танай өрхийн амьдардаг сууц хэдэн унтлагын өрөөтэй вэ?
V37	HC2A	Гэрийн ханын тоо	contin	numeric	Танай өрхийн амьдардаг гэр хэдэн ханатай вэ?
V38	НС3	Сууцны шалны үндсэн материал	discrete	numeric	Танай өрхийн амьдардаг сууцны шалны үндсэн материал юу вэ?
V39	HC4	Сууцны дээврийн үндсэн материал	discrete	numeric	Танай өрхийн амьдардаг сууцны дээврийн үндсэн материал юу вэ?
V40	HC5	Сууцны ханын үндсэн материал	discrete	numeric	Танай өрхийн амьдардаг сууцны ханын үндсэн материал юу вэ?
V41	HC5A	Сууцны эзэмшил	discrete	numeric	Танай өрхийн амьдардаг сууцны эзэмшлийн хэлбэр юу вэ?
V42	HC6	Хоолоо бэлтгэхэд хэрэглэдэг түлшний төрөл	discrete	numeric	Хоолоо бэлтгэхдээ голдуу ямар төрлийн түлш хэрэглэдэг вэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V43	HC7	Хоолоо болгоход ашигладаг зуух, пиишин, галын төрөл	discrete	numeric	Хоолоо юу ашиглаж болгодог вэ?
V44	HC8	Хоолоо хийдэг газар	discrete	numeric	Хоолоо хаана хийдэг вэ?
V45	НС9А	Цахилгаан гэрэл байгаа	discrete	numeric	Танай өрхөд цахилгаан гэрэл бий юу?
V46	НС9В	Радио, хүлээн авагч байгаа	discrete	numeric	Танай өрхөд радио, хүлээн авагч бий юу?
V47	НС9С	Телевизор байгаа	discrete	numeric	Танай өрхөд телевизор бий юу?
V48	НС9СА	Компьютер байгаа	discrete	numeric	Танай өрхөд компьютер бий юу?
V49	HC9D	Хөдөлгөөнт телефон утас байгаа	discrete	numeric	Танай өрхөд хөдөлгөөнт телефон утас бий юу?
V50	HC9E	Суурин телефон утас байгаа	discrete	numeric	Танай өрхөд суурин телефон утас бий юу?
V51	HC9F	Хөргөгч байгаа	discrete	numeric	Танай өрхөд хөргөгч бий юу?
V52	HC10A	Бугуйн цаг байгаа	discrete	numeric	Танай өрхийн гишүүдийн хэн нэгэнд бугуйн цаг бий юу?
V53	HC10B	Унадаг дугуй байгаа	discrete	numeric	Танай өрхийн гишүүдийн хэн нэгэнд унадаг дугуй бий юу?
V54	HC10C	Мотоцикл байгаа	discrete	numeric	Танай өрхийн гишүүдийн хэн нэгэнд мотоцикл бий юу?
V55	HC10D	Ердийн хөсөг байгаа	discrete	numeric	Танай өрхийн гишүүдийн хэн нэгэнд ердийн хөсөг бий юу?
V56	HC10EA	Трактор байгаа	discrete	numeric	Танай өрхийн гишүүдийн хэн нэгэнд трактор бий юу?
V57	HC10EB	Автомашин байгаа	discrete	numeric	Танай өрхийн гишүүдийн хэн нэгэнд автомашин бий юу?
V58	HC10F	Моторт завь байгаа	discrete	numeric	Танай өрхийн гишүүдийн хэн нэгэнд моторт завь бий юу?
V59	HC11	Хувийн тариалангийн талбай эзэмшдэг	discrete	numeric	Танайх хувийн тариалангийн талбай эзэмшдэг үү?
V60	HC12U	Тариалангийн талбайн хэмжих нэгж	discrete	numeric	Ямар хэмжээтэй хувийн тариалангийн талбай эзэмшдэг вэ?
V61	HC12N	Тариалангийн талбайн хэмжээ	contin	numeric	Ямар хэмжээтэй хувийн тариалангийн талбай эзэмшдэг вэ?
V62	HC13	Хувийн малтай	discrete	numeric	Танайх хувийн малтай юу?
V63	HC14A	Үхэрний тоо	contin	numeric	Хэдэн үхэртэй вэ?
V64	HC14AA	Үнээний тоо	contin	numeric	Хэдэн үнээтэй вэ?
V65	HC14AB	Бухын тоо	contin	numeric	Хэдэн бухтай вэ?
V66	HC14B	Адууны тоо	contin	numeric	Хэдэн адуутай вэ?
V67	HC14C	Ямааны тоо	contin	numeric	Хэдэн ямаатай вэ?
V68	HC14D	Хоньний тоо	contin	numeric	Хэдэн хоньтой вэ?
V69	HC14E	Тэмээний тоо	contin	numeric	Хэдэн тэмээтэй вэ?
V70	HC14F	Тахианы тоо	contin	numeric	Хэдэн тахиатай вэ?
V71	HC14G	Гахайны тоо	contin	numeric	Хэдэн гахайтай вэ?
V72	HC14X	Бусад мал, амьтны тоо	contin	numeric	Хэдэн бусад амьтадтай вэ?
V73	CD7	Өрхийн 2-14 насны хүүхдийн тоо	contin	numeric	
V74	CD9	Сонгогдсон хүүхдийн сонголтын хүснэгт дэхь дугаар	contin	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V75	CD11	Сонгогдсон хүүхдийн мөрийн дугаар	discrete	numeric	
V76	CD12B	Гаргасан зан ааш нь буруу болохыг түүнд тайлбарлаж хэлсэн	discrete	numeric	Гаргасан зан ааш нь буруу болохыг түүнд тайлбарлаж хэлсэн үү?
V77	CD12D	Түүнийг загнасан	discrete	numeric	Түүнийг загнасан уу?
V78	CD12E	Түүнийг шийтгэж, ямар нэг ажил хийлгэхээр өгсөн	discrete	numeric	Түүнийг шийтгэж, ямар нэг ажил хийлгэхээр өгсөн үү?
V79	CD12H	Түүнийг тэнэг, залхуугаар нь дуудсан	discrete	numeric	Түүнийг тэнэг, залхуугаар нь дуудсан уу?
V80	CD12K	Түүнийг зодсон	discrete	numeric	Түүнийг зодсон уу?
V81	CD13	Хүүхдэд бие мах бодийн шийтгэл оногдуулах нь түүний хүмүүжилд сайнаар нөлөөлнө гэдэгт итгэдэг	discrete	numeric	Хүүхдэд бие мах бодийн шийтгэл оногдуулах нь түүний хүмүүжилд сайнаар нөлөөлнө гэдэгт итгэдэг үү?
V82	CD14	Түүний хөгжил, хүмүүжилд илүү анхаарал тавьдаг хүн	discrete	numeric	Түүний хөгжил, хүмүүжилд хэн илүү анхаарал тавьдаг вэ?
V83	CD15	Хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар сүүлийн 1 сард ямар нэг мэдээлэл авсан	discrete	numeric	Хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар сүүлийн 1 сард ямар нэг мэдээлэл авсан уу?
V84	CD16	Хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар мэдээлэл авдаг эх үүсвэр	discrete	numeric	Хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар мэдээллийг хаанаас авдаг вэ?
V85	CD17	Түүний хүсэлтийг сонсдог	discrete	numeric	Түүний хүсэлтийг хэр сонсдог вэ?
V86	CD18	Түүний хэрэгцээ, сонирхлыг өөрөөс нь асуудаг	discrete	numeric	Түүний хэрэгцээ, сонирхлыг өөрөөс нь асуудаг уу?
V87	CD19	Түүнийг магтдаг	discrete	numeric	Түүнийг хэр зэрэг магтдаг вэ?
V88	CD20	Түүнд тоглоом, наадгай авч өгдөг	discrete	numeric	Түүнд тоглоом, наадгай авч өгдөг үү?
V89	CD21	Түүнд зургийн дэвтэр, харандаа авч өгдөг	discrete	numeric	Түүнд зургийн дэвтэр, харандаа авч өгдөг үү?
V90	CD22	Сүүлийн 1 сарын дотор гэмтэл авсан	discrete	numeric	Сүүлийн 1 сарын дотор гэмтэл авсан уу?
V91	CD23	Гэмтлийн шалтгаан	discrete	numeric	Юунаас болж гэмтэл авсан бэ?
V92	CD24	Тогтмол цагт хооллодог	discrete	numeric	Тогтмол цагт хооллодог уу?
V93	CD25	Тогтмол цагт унтдаг	discrete	numeric	Тогтмол цагт унтдаг уу?
V94	CD26	Өглөө шүдээ угааж хэвшсэн	discrete	numeric	Өглөө шүдээ угааж хэвшсэн үү?
V95	CD27	Хоолны өмнө гараа угааж хэвшсэн	discrete	numeric	Хоолны өмнө гараа угааж хэвшсэн үү?
V96	CD28	Бие засаад гараа угааж хэвшсэн	discrete	numeric	Бие засаад гараа угааж хэвшсэн үү?
V97	CD29	Усанд тогтмол ордог	discrete	numeric	Усанд тогтмол ордог уу?
V98	CD30	Унтахын өмнө шүдээ угааж хэвшсэн	discrete	numeric	Унтахын өмнө шүдээ угааж хэвшсэн үү?
V99	CD31	Цаг агаарт тохируулан хувцасладаг	discrete	numeric	Цаг агаарт тохируулан хувцасладаг уу?
V100	IH1011	Цалин, бэлнээр /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн цалингийн орлого (бэлнээр) хэд байсан бэ?
V101	IH1012	Цалин, бэлнээр /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн цалингийн орлого (бэлнээр) хэд байсан бэ?
V102	IH1021	Цалин, мөнгөн бус хэлбэрээр /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн цалингийн орлого (мөнгөн бус хэлбэрээр) хэд байсан бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V103	IH1022	Цалин, мөнгөн бус хэлбэрээр /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн цалингийн орлого (мөнгөн бус хэлбэрээр) хэд байсан бэ?
V104	IH1031	Тэтгэвэр /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн тэтгэврийн орлого хэд байсан бэ?
V105	IH1032	Тэтгэвэр /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн тэтгэврийн орлого хэд байсан бэ?
V106	IH1041	Нөхөн олговор /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн нөхөн олговрын орлого хэд байсан бэ?
V107	IH1042	Нөхөн олговор /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн нөхөн олговрын орлого хэд байсан бэ?
V108	IH1051	Тэтгэмж /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн тэтгэмжийн орлого хэд байсан бэ?
V109	IH1052	Тэтгэмж /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн тэтгэмжийн орлого хэд байсан бэ?
V110	IH1061	Хүүхдийн мөнгө /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн хүүхдийн мөнгөний орлого хэд байсан бэ?
V111	IH1062	Хүүхдийн мөнгө /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн хүүхдийн мөнгөний орлого хэд байсан бэ?
V112	IH1991	Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нийт орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нийт орлого хэд байсан бэ?
V113	IH1992	Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нийт орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нийт орлого хэд байсан бэ?
V114	IH2011	Мал аж ахуйгаас олсон орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн мал аж ахуйгаас олсон орлого хэд байсан бэ?
V115	IH2012	Мал аж ахуйгаас олсон орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн мал аж ахуйгаас олсон орлого хэд байсан бэ?
V116	IH2021	Газар тариалангаас олсон орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн газар тариалангаас олсон орлого хэд байсан бэ?
V117	IH2022	Газар тариалангаас олсон орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн газар тариалангаас олсон орлого хэд байсан бэ?
V118	IH2031	Бусад үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн бусад үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон орлого хэд байсан бэ?
V119	IH2032	Бусад үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн бусад үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон орлого хэд байсан бэ?
V120	IH2991	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон нийт орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон нийт орлого хэд байсан бэ?
V121	IH2992	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон нийт орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон нийт орлого хэд байсан бэ?
V122	IH3011	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого хэд байсан бэ?
V123	IH3012	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого хэд байсан бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V124	IH3021	Хувьцааны ногдол ашгаас олсон орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн хувьцааны ногдол ашгаас олсон орлого хэд байсан бэ?
V125	IH3022	Хувьцааны ногдол ашгаас олсон орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн хувьцааны ногдол ашгаас олсон орлого хэд байсан бэ?
V126	IH3031	Байр, өмч хөрөнгийн түрээсийн орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн байр, өмч хөрөнгийн түрээсийн орлого хэд байсан бэ?
V127	IH3032	Байр, өмч хөрөнгийн түрээсийн орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн байр, өмч хөрөнгийн түрээсийн орлого хэд байсан бэ?
V128	IH3041	Оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн орлого хэд байсан бэ?
V129	IH3042	Оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн орлого хэд байсан бэ?
V130	IH3051	Хадгаламжаас авсан, бусдад зээлдүүлсэн мөнгөнөөс эргэж төлөгдсөн орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн хадгаламжаас авсан, бусдад зээлдүүлсэн мөнгөнөөс эргэж төлөгдсөн орлого хэд байсан бэ?
V131	IH3052	Хадгаламжаас авсан, бусдад зээлдүүлсэн мөнгөнөөс эргэж төлөгдсөн орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн хадгаламжаас авсан, бусдад зээлдүүлсэн мөнгөнөөс эргэж төлөгдсөн орлого хэд байсан бэ?
V132	IH3061	Хадгаламж, бусдад зээлдүүлсэн мөнгөний хүү /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн хадгаламж, бусдад зээлдүүлсэн мөнгөний хүүний орлого хэд байсан бэ?
V133	IH3062	Хадгаламж, бусдад зээлдүүлсэн мөнгөний хүү /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн хадгаламж, бусдад зээлдүүлсэн мөнгөний хүүний орлого хэд байсан бэ?
V134	IH3071	Бусдаас авсан бэлэг, тусламж /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн бусдаас авсан бэлэг, тусламжийн орлого хэд байсан бэ?
V135	IH3072	Бусдаас авсан бэлэг, тусламж /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн бусдаас авсан бэлэг, тусламжийн орлого хэд байсан бэ?
V136	IH3081	Шагнал урамшуулал /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн шагнал урамшууллын орлого хэд байсан бэ?
V137	IH3082	Шагнал урамшуулал /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн шагнал урамшууллын орлого хэд байсан бэ?
V138	IH3091	Үйлдвэрлэлийн бус зориулалтаар авсан зээл /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн үйлдвэрлэлийн бус зориулалтаар авсан зээлийн орлого хэд байсан бэ?
V139	IH3092	Үйлдвэрлэлийн бус зориулалтаар авсан зээл /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн үйлдвэрлэлийн бус зориулалтаар авсан зээлийн орлого хэд байсан бэ?
V140	IH3101	Бусад орлогын эх үүсвэрээс олсон орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн бусад орлогын эх үүсвэрээс олсон орлого хэд байсан бэ?
V141	IH3102	Бусад орлогын эх үүсвэрээс олсон орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн бусад орлогын эх үүсвэрээс олсон орлого хэд байсан бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V142	IH3991	Бусад нийт орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн бусад нийт орлого хэд байсан бэ?
V143	IH3992	Бусад нийт орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн бусад нийт орлого хэд байсан бэ?
V144	IH4991	Нийт орлого /сүүлийн сард/	contin	numeric	Сүүлийн сард танай өрхийн гишүүдийн нийт орлого хэд байсан бэ?
V145	IH4992	Нийт орлого /сүүлийн 12 сард/	contin	numeric	Сүүлийн 12 сард танай өрхийн гишүүдийн нийт орлого хэд байсан бэ?
V146	SI1	Хүнсэнд хэрэглэж буй давсны иоджуулалт	discrete	numeric	Танай хүнсэндээ хэрэглэж буй давсны иоджуулалтыг шалгаж үзье. Урьд шөнө хоолоо хийхдээ хэрэглэсэн давснаас хэсгийг авч болох уу?
V147	SI1A	Давсны төрөл	discrete	numeric	Танайх хүнсэндээ ямар давс хэрэглэдэг вэ?
V148	SI1B	Эрдэс, амин дэмээр баяжуулсан гурилын талаар сонсож байсан	discrete	numeric	Та эрдэс, амин дэмээр баяжуулсан гурилын талаар сонсож байсан уу?
V149	SI1C	Эрдэс, амин дэмээр баяжуулсан гурил хэрэглэдэг	discrete	numeric	Танайх эрдэс, амин дэмээр баяжуулсан гурил хэрэглэдэг үү?
V150	нн6	Хот, хөдөө	discrete	numeric	
V151	HH7	Бүс	discrete	numeric	
V152	stratum	Түүврийн бүлэг	discrete	numeric	
V153	hhweight	Өрхийн түүврийн жин	contin	numeric	
V154	hhmemwt	Өрхийн гишүүдийн түүврийн жин	contin	numeric	
V155	helevel	Өрхийн тэргүүлэгчийн боловсрол	discrete	numeric	
V156	hhsex	Өрхийн тэргүүлэгчийн хүйс	discrete	numeric	
V157	wlthscor	Аж байдлын индексийн оноо	contin	numeric	
V158	wlthind5	Аж байдлын индекс	discrete	numeric	

### **Household Roster**

Агуулга Өрхийн гишүүдийн мэдээллийн файл (ОҮБТС өрхийн асуулга: өрхийн гишүүдийн ерөнхий

мэдээлэл, боловсрол, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэсэн бүлгүүд)

Тохиолдолууд 26718

Хувьсагч 126

Бүтэц Төрөл: relational

Түлхүүрүүд: НН1(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), НН2(Өрхийн дугаар)

Хувилбар х2.0: засварлагдсан мэдээлэл, зөвхөн дотоод хэрэгцээнд

Гүйцэтгэгч Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар

Мэдээллийн файлд байгаа онцлог хариулт болон орхигдсон хариултуудыг дараах маягаар кодлосон: Асуулгын дагуу зарим асуултыг асуулгүй үсрэх тохиолдол байдаг ба энэ тохиолдолд хариултыг хоосон орхисон байгаа. Зарим асуугдах ёстой асуултын хувьд мэдээлэгч ямар нэг хариулт өгөөгүй байвал түүнийг компьютерт оруулахдаа тоон төрлийн хариулт авах асуултын хувьд 9, 99, ..., тэмдэгт төрлийн хариулт авах асуултын хувьд ?, ??, ... гэх мэтээр кодлож шивсэн.

Бусад онцгой хариултыг дараах байдлаар кодлосон. Үүнд: тоон төрлийн хариулт авах асуултын хувьд Мэдэхгүй 8, 98, ... Таарахгүй 7, 97, ... Бусад 6, 96, ... Харин, тэмдэгт төрлийн хариулт авах

асуултын хувьд: Мэдэхгүй Z Аль нь ч биш Y Бусад X Нэгтгэн дүгнэвэл: 1 орон 2 орон 3 орон 4 орон Тэмдэгт Хариулах ёсгүй . . . . . Орхигдсон 9 99 999 9999 ? Мэдэхгүй 8 98 998 9998 Z Таарахгүй 7 97 997 9997 Аль нь ч биш 0 00 000 0000 Y Бусад 6 96 996 9996 X Онцлог хариулт

95,94,... 995,994,... 9995,9994,... W

### Хувьсагчид

Missing Data

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V159	HH1	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	discrete	numeric	
V160	HH2	Өрхийн дугаар	discrete	numeric	
V161	HL1	Өрхийн гишүүдийн мөрийн дугаар	discrete	numeric	
V162	HL3	Өрхийн тэргүүлэгчтэй хамаарал	discrete	numeric	(Нэр) өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ?
V163	HL4	Хүйс	discrete	numeric	(Нэр) эрэгтэй юу, эмэгтэй юу?
V164	HL4A	Төрсөн он	contin	numeric	(Нэр) хэдэн онд төрсөн бэ?
V165	HL5	Нас	contin	numeric	(Нэр) бүтэн жилээр хэдэн настай вэ?
V166	HL6	15-49 насны эмэгтэйчүүдийн мөрийн дугаар	discrete	numeric	
V167	HL7	5-17 насны хүүхдийн эх/асрагчийн мөрийн дугаар	discrete	numeric	(Нэр)-ийн эх/асран хамгаалагч нь хэн бэ?
V168	HL8	5 хүртэлх насны хүүхдийн эх/асрагчийн мөрийн дугаар	discrete	numeric	(Нэр)-ийн эх/асран хамгаалагч нь хэн бэ?
V169	HL9	Төрсөн эх амьд байгаа	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эх нь амьд байгаа юу?
V170	HL10	Хамт амьдарч байгаа төрсөн эхийн мөрийн дугаар	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эх нь танай өрхөд хамт амьдардаг уу?
V171	HL11	Төрсөн эцэг амьд байгаа	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эцэг нь амьд байгаа юу?
V172	HL12	Хамт амьдарч байгаа төрсөн эцгийн мөрийн дугаар	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эх нь танай өрхөд хамт амьдардаг уу?
V173	ED1	Өрхийн 5 ба түүнээс насны гишүүдийн мөрийн дугаар	discrete	numeric	
V174	ED2	Цэцэрлэг, сургуульд хамрагдаж байсан	discrete	numeric	(Нэр) цэцэрлэг, сургуульд хамрагдаж байсан уу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V175	ED3A	Суралцаж төгссөн сургууль	discrete	numeric	(Нэр) ямар төрлийн сургууль суралцаж төгссөн бэ?
V176	ED3B	Суралцаж төгссөн анги	discrete	numeric	(Нэр) хэддүгээр анги төгссөн бэ?
